



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/99/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	
3.8 Аудитын гол асуудал	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 139

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулалгүйгээр хүүхдийн хоол бэлтгэсэн, татварын тайлан буруу тайлагнасан, татвараас авах авлагыг бүртгэж тайлагнаагүй, и баримтгүй гүйлгээ хийсэн, шилэн дансны мэдээлэл дутуу, шатахууны тооцоо бодоогүй, нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй зэрэг материаллаг 849.6 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Татварын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07100342

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	176,061,895.76	152,952,821.21
33	АВЛАГА	-	41,966.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	41,966.00
35	БАРАА МАТЕРИАЛ	176,061,895.76	152,910,855.21
35100	Түүхий эд материал	103,257,481.60	104,660,615.05
35110	Тусгай зориулалттай материал	102,179,481.60	103,672,615.05
35130	Эм боох материал	1,078,000.00	988,000.00
35400	Хангамжийн материал	72,804,414.16	48,250,240.16
35410	Бичиг хэргийн материал	1,218,700.00	1,258,456.00
35420	Аж ахуйн материал	7,468,080.00	5,624,950.00
35440	Түлш, шатах тослох материал	15,980,000.00	12,600,000.00
35450	Барилгын засварын материал	3,066,000.00	934,000.00
35460	Хүнсний материал	2,133,490.00	5,277,190.00
35470	Бусад хангамжийн материал	42,938,144.16	22,555,644.16
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	852,979,442.98	892,647,953.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	852,979,442.98	892,647,953.71
39200	Биет хөрөнгө	828,380,942.98	868,049,453.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	857,630,686.59	895,207,686.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(150,510,482.24)	(187,256,397.80)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	198,496,834.48	184,533,876.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(184,577,778.63)	(139,731,103.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,222,414.90	133,298,702.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(92,083,291.05)	(91,733,437.70)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	84,332,160.28	84,332,160.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,129,601.35)	(15,487,528.25)
39217	Ном	-	1,885,494.92
39300	Биет бус хөрөнгө	24,598,500.00	24,598,500.00
39301	Програм хангамж	2,615,298.00	2,615,298.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,615,298.00)	(2,615,298.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	24,598,500.00	24,598,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,029,041,338.74	1,045,600,774.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,029,041,338.74	1,045,600,774.92
51	Засгийн газрын хувь оролцоо	1,029,041,338.74	1,045,600,774.92
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,181,487,146.10	1,181,487,146.10
51200	Хуримтлагдсан үр дүн	(464,077,658.19)	(447,518,222.01)
51210	Өмнөх үеийн үр дүн	(418,061,224.60)	(464,077,658.19)
51220	Тайлант үеийн үр дүн	(46,016,433.59)	16,559,436.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	311,631,850.83	311,631,850.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,029,041,338.74	1,045,600,774.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,039,502,683.00	1,062,284,625.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,360,173.00	74,355,169.37
120	Нийтлэг татварын бус орлого	56,360,173.00	74,355,169.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,231,661.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	52,231,661.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	72,975,255.92
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,128,512.00	1,379,913.45
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	983,142,510.00	987,929,456.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	895,273,900.00	913,388,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	895,273,900.00	913,388,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,841,610.00	4,541,156.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,841,610.00	4,541,156.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,027,000.00	70,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,027,000.00	70,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,085,519,116.59	1,025,022,689.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,085,519,116.59	1,025,022,689.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	994,547,928.59	977,023,771.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	689,133,374.00	707,738,642.00
210101	Үндсэн цалин	577,260,182.00	602,921,336.00
210104	Урамшуулал	56,602,667.00	50,304,915.00
210105	Гэрээт ажлын хөлс	55,270,525.00	54,512,391.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,646,747.72	90,524,309.00
210201	Тэтгэврийн даатгал	60,518,182.00	63,929,633.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,709,667.00	6,895,133.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,437,467.00	5,479,345.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,241,188.00	1,291,801.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,740,243.72	12,928,397.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,796,254.00	73,316,965.00
210301	Гэрэл, цахилгаан	5,272,754.00	6,865,715.00
210302	Түлш, халаалт	56,940,500.00	62,651,250.00
210303	Цэвэр, бохир ус	3,583,000.00	3,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,690,492.00	15,456,010.00
210401	Бичиг хэрэг	1,625,782.00	4,307,700.00
210402	Тээвэр, шатахуун	7,679,070.00	2,824,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	298,740.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	129,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,666,900.00	7,895,310.00
2105	Нормативт зардал	31,290,330.00	37,003,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	590,000.00	995,000.00
210502	Хоол, хүнс	30,700,330.00	36,008,100.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,100,000.00	2,132,000.00
210604	Урсгал засвар	2,100,000.00	2,132,000.00
2107	Томилолт, зочны зардал	802,000.00	156,000.00
210702	Дотоод албан томилолт	802,000.00	156,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,000.00	240,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,292,730.87	50,456,745.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	215,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,077,730.87	50,456,745.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,971,188.00	47,998,918.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,061,510.00	31,512,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,875,400.00	25,602,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,841,610.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,344,500.00	5,910,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,458,246.00	63,035.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,458,246.00	63,035.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,451,432.00	16,423,683.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,451,432.00	16,423,683.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(46,016,433.59)	37,261,936.18
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	20,702,500.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	20,702,500.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(46,016,433.59)	16,559,436.18

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	983,142,510.00	987,929,456.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	983,142,510.00	987,929,456.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	895,273,900.00	913,388,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	895,273,900.00	913,388,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,841,610.00	4,541,156.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,841,610.00	4,541,156.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,027,000.00	70,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,027,000.00	70,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	983,142,510.00	970,779,456.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	983,142,510.00	970,779,456.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	892,171,322.00	922,780,538.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	689,133,374.00	707,780,608.00
210101	Үндсэн цалин	577,260,182.00	602,963,302.00
210104	Урамшуулал	56,602,667.00	50,304,915.00
210105	Гэрээт ажлын хөлс	55,270,525.00	54,512,391.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,569,372.00	90,524,309.00
210201	Тэтгэврийн даатгал	60,518,182.00	63,929,633.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,709,667.00	6,895,133.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,437,467.00	5,479,345.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,241,188.00	1,291,801.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,662,868.00	12,928,397.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,468,754.00	69,936,965.00
210301	Гэрэл, цахилгаан	5,272,754.00	6,865,715.00
210302	Түлш, халаалт	58,613,000.00	59,271,250.00
210303	Цэвэр, бохир ус	3,583,000.00	3,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,555,492.00	9,044,556.00
210401	Бичиг хэрэг	1,759,682.00	3,268,156.00
210402	Тээвэр, шатахуун	7,679,070.00	2,824,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	298,740.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	320,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,090,000.00	129,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,578,000.00	2,203,400.00
2105	Нормативт зардал	26,586,330.00	43,058,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,230,000.00	2,147,000.00
210502	Хоол, хүнс	24,672,930.00	39,151,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	683,400.00	1,760,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,060,000.00	960,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	960,000.00	960,000.00
210604	Урсгал засвар	2,100,000.00	-

2107	Томилолт, зочны зардал	802,000.00	156,000.00
210702	Дотоод албан томилолт	802,000.00	156,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,000.00	240,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	1,079,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	1,079,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,971,188.00	47,998,918.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,061,510.00	31,512,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,875,400.00	25,602,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,841,610.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,344,500.00	5,910,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,458,246.00	63,035.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,458,246.00	63,035.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,451,432.00	16,423,683.00
213502	Хаагдсан данс	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,451,432.00	16,423,683.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	17,150,000.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	17,150,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	17,150,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	17,150,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	17,150,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(17,150,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	(418,061,224.60)	1,075,057,772.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	(418,061,224.60)	1,075,057,772.33
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(46,016,433.59)	(46,016,433.59)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	(464,077,658.19)	1,029,041,338.74
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	(464,077,658.19)	1,029,041,338.74
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	(464,077,658.19)	1,029,041,338.74
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	16,559,436.18	16,559,436.18
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	(447,518,222.01)	1,045,600,774.92

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	983,388,300.00	966,901,582.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	983,388,300.00	966,901,582.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	950,160,600.00	935,389,382.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	717,458,200.00	707,780,608.00
210101	Үндсэн цалин	609,536,200.00	602,963,302.00
210102	Нэмэгдэл	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	52,568,000.00	50,304,915.00
210105	Гэрээт ажлын хөлс	55,354,000.00	54,512,391.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,816,700.00	90,524,309.00
210201	Тэтгэврийн даатгал	67,569,000.00	63,929,633.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,776,000.00	6,895,133.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,486,200.00	5,479,345.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,361,000.00	1,291,801.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,624,500.00	12,928,397.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,000,000.00	69,936,965.00
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	6,865,715.00
210302	Түлш, халаалт	60,000,000.00	59,271,250.00
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	3,800,000.00
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	6,653,400.00	6,653,400.00
210401	Бичиг хэрэг	1,177,000.00	1,177,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,524,000.00	2,524,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	320,000.00	320,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	129,000.00	129,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,203,400.00	2,203,400.00
2105	Нормативт зардал	43,059,000.00	43,058,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,147,000.00	2,147,000.00
210502	Хоол, хүнс	39,152,000.00	39,151,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,760,000.00	1,760,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,960,000.00	15,960,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	960,000.00	960,000.00
210604	Урсгал засвар	-	-
2107	Томилолт, зочны зардал	318,000.00	156,000.00
210701	Гадаад албан томиллолт	-	-
210702	Дотоод албан томиллолт	318,000.00	156,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	816,000.00	240,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	816,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,079,300.00	1,079,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,079,300.00	1,079,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,227,700.00	31,512,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,227,700.00	31,512,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,727,700.00	25,602,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500,000.00	5,910,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	983,388,300.00	966,901,582.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	913,388,300.00	896,964,617.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	913,388,300.00	896,964,617.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,000,000.00	69,936,965.00
320001	Орон нутгийн төсвөөс	70,000,000.00	69,936,965.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,541,156.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,541,156.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,391,156.00
210401	Бичиг хэрэг	2,091,156.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,150,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,150,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,541,156.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,541,156.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,541,156.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 13 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол Улсын засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 912.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 14.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны нийт зардал 1,025.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 20.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16.4 сая төгрөгөөр тооцсон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,8 хувиар буюу 16.0 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 152.5 сая төгрөг болж 23.1 сая төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалаас 20.7 сая төгрөгийн материалыг үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 113.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 1.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 117.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,329.4 сая төгрөг болж 35.5 сая төгрөгөөр өссөн нь 17.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, бараа материалаас 20.7 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, 37.8 сая төгрөгөөр барилга капиталжуулсан, 12.8 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой. Тайлант хугацаанд 54.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,045.5 сая төгрөг болж 16.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 2.3 сая төгрөгөөр

өссөн нь үнэ төлбөргүй авсан бараа материал үндсэн хөрөнгө өссөнтэй холбоотой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -447.5 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,153.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 169.7 сая төгрөгөөр бууруулж, 983.4 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 983.4 сая төгрөгийн төсөв баталснаас 913.4 сая төгрөгийг улсын төсвөөс 70.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 913.4 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 70.0 сая төгрөг, нийт 983.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 966.9 сая төгрөгийг зарцуулж 16.5 сая төгрөгийг улсын төсөвт, 0.06 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 966.9 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 9.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлээс 4.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.1 сая төгрөгөөр, томилолт зочны зардлаас 0.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардаас 0.6 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгээс 1.8 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 4.5 сая төгрөгийн гүйлгээ хийгдэн, 2.3 сая төгрөгийг хангамж бараа материалын зардалд, 2.2 сая төгрөгийг багаж техник хэрэгслийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийг орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 132 мэдээллээс мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба 13 мэдээллийг хугацаа хоцроосон. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 872.8 сая төгрөгийн 12 орлогын гүйлгээ мэдээлээгүй байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн зарим холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1 дэх заалт "Захиалагч бараа, ажил үйлчилгээ, худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна., 8.5 дахь заалт "энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ

худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн заалтыг зөрчсөн

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 212.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелэлт ирүүлсэн боловч зөрчил дахин давтагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

- Нягтлан бодох бүртгэлийн бичилт
- Худалдан авах үйл ажиллагаа, холбогдох гэрээ, анхан шатны баримт
- Цалин нэмэгдэл хөлс, тушаал шийдвэрийн биелэлт
- Шатахууны зарцуулалт тооцоо бодолт
- Шилэн дансны мэдээлэлийн тоон үзүүлэлтүүд
- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн эсэхийг зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 871.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.1 сая төгрөгийн алдааг залруулж, 840.3 төгрөгийн зөрчилд албан шаардлага, 10 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Нийгмийн даатгалын хоорондын тооцоогоор үүссэн 0.04 сая төгрөгийн авлага, үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн 20.7 сая төгрөгийн, бараа материалын дансанд үнэ төлбөргүй хүлээн авсан 0.3 сая төгрөгийн материалыг бүртгэж, зөрчлийг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

- Тайлант онд 809.2 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгал, бусад зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1. анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2. журналд бичих, 14.3.3. дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4. ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5. санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ
- Татварын тайланг цалингийн цэснээс 2.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "Татвар төлөгч суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах" гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүллээ.

- Тайлант онд 2.8 сая төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.
- Татварын тодорхойлотоорх 0.05 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.
- Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 25.4 сая төгрөгийн хоол, бэлтгэсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1 дэх заалт "Захиалагч бараа, ажил үйлчилгээ, худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна., 8.5 дахь заалт "энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.
- Шилэн дансанд мэдээлэх 148 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Нийт 945.4 сая төгрөгийн орлогын гүйлгээ шивээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" гэж заасныг тус тус зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.

➤ 4.4 Зөвлөмж

1. Худалдан авалттай холбоотой

- 1.1. Илрүүлэлт: Нэг бэлтгэн нийлүүлэгчээс худалдах худалдан авах гэрээгүйгээр 10.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн
- 1.2. Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангаагүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Худалдах худалдан авах гэрээ байгуулж байх
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цогт сумын Ерөнхий боловсролын сургууль	11	871.4	3	21.1	-	-	7	840.3	1	10.0
	Дүн	11	871.4	3	21.1	-	-	7	840.3	1	10.0



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/99/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	176.0	153.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	852.9	892.6
	Нийт хөрөнгийн дүн	1,029.0	1,045.6
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,029.0	1,045.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,029.0	1,045.6
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,039.5	1,062.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,085.5	1,025.0
	Үйл ажиллагааны үр дүн	-46.0	37.2
	Үйл ажиллагааны бус үр дүн		-20.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-46.0	16.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,029.0	1,029.0
	Тайлант оны үр дүн		16.6
	Эцсийн үлдэгдэл	1,029.0	1,045.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	983.1	987.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	983.1	970.7
	Үйл ажиллагааны ЦМГ	0.0	17.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		-17.2
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		966.9
	Урсгал зардал		966.9
	Хөрөнгийн зардал		0.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		966.9
	Улсын төсвөөс санхүүжих		966.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага , түүний үйл ажиллагаа

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 13 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол Улсын засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 132 мэдээллээс 119 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба 13 мэдээллийг хугацаа хоцроосон. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 872.8 сая төгрөгийн 12 орлогын гүйлгээ мэдээлээгүй байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн зарим холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1 дэх заалт "Захиалагч бараа, ажил үйлчилгээ, худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна., 8.5 дахь заалт "энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн заалтыг зөрчсөн.

ЗУРГАА. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

- Нягтлан бодох бүртгэлийн бичилт
- Худалдан авах үйл ажиллагаа, холбогдох гэрээ, анхан шатны баримт
- Цалин нэмэгдэл хөлс, тушаал шийдвэрийн биелэлт
- Шатахууны зарцуулалт тооцоо бодолт
- Шилэн дансны мэдээлэлийн тоон үзүүлэлтүүд
- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн эсэхийг зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 871.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.1 сая төгрөгийн алдааг залруулж, 840.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 10 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа

Нийгмийн даатгалын хоорондын тооцоогоор үүссэн 0.04 сая төгрөгийн авлага, үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн 20.7 сая төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 0.3 сая төгрөгийн материалыг бараа материалын дансанд бүртгэж, зөрчлийг залруулав.

Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

Албан шаардлага

Тайлант онд 809.2 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгал, бусад зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах,

14.3.5. санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тайланг цалингийн цэснээс 2.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "татвар төлөгч суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах" гэсэн заалтыг зөрчсөн" тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд 2.8 сая төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлоотоорх 0.05 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.

